

**ИХ ЮАНЬ УЛСЫН “УЛСЫН ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛЬ”-ИЙН  
ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ**

ДАВААЦЭРЭНГИЙН ИДЭР  
*МУБИС-ийн Түүхийн тэнхимийн ахлах багш*

ХОСБАЯР (SHUANGXI)  
*МУБИС-ийн Түүхийн тэнхимийн докторант,  
БНХАУ-ын Өвөр Монголын Улаанхад Дээд Сургуулийн багш*

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэлд Их Юань улсын (XIII–XIV зуун) төрийн боловсролын тогтолцооны гол цөм болсон Улсын хөвгүүдийн сургуулиудын үүсэл, бүтэц, захиргаа, сургалтын дүрэм, багш суралцагчдын бүрэлдэхүүнийг түүхийн сурвалж бичгийн мэдээ баримтад тулгуурлан авч үзлээ. Хубилай хааны үед төрийн түшмэдийг бэлтгэх бодлогын хүрээнд Улсын хөвгүүдийн сургууль, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль, Сартуулын улсын хөвгүүдийн сургууль гэсэн гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулжээ. Улсын хөвгүүдийн сургууль нь Өгэдэй хааны үеэс үүсэлтэй бөгөөд Хубилай хааны үед зохион байгуулалт, сургалтын агуулга, захиргааны бүтцэд шинэчлэл хийж, их нийслэл Хаанбалгас хотод төвлөрөн хөгжсөн төдийгүй дээд нийслэл Шанду хотод салбар сургууль байгуулснаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломж бүрджээ. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль нь Пагва ламын зохиосон дөрвөлжин бичгийг зааж сургах зорилготойгоор байгуулагдаж, угсаатны ялгааг үл харгалзан төрийн бичгийн хэрэг хөтлөх чадвартай түшмэдийг бэлтгэхэд чиглэж байв. Харин Сартуулын улсын хөвгүүдийн сургууль нь араб, перс хэлтэй буюу “өнгөт нүдтэн” түшмэдийг сургах замаар гадаад харилцаа, санхүү, тооцооны салбарт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх үүрэгтэй байжээ. Эдгээр гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг тус тусад нь байгуулсан байна. Энэ нь эдгээр гурван сургуулийн зорилго, чиг үүрэг, онцлогтой холбоотой юм. Улсын хөвгүүдийн сургуулиудын дүрэм журам нь анги дэвшүүлэх дүрэм, шалгалтын онооны дүрэм, сахилга шийтгэлийн дүрмээр бүрэлдэж байжээ. Сургуулийн багш нь эрдэмтэн, туслах сургагч, гол сургагч, сургалтын тэмдэглэгч гэсэн зэрэглэлтэй байв. Суралцагчид үндсэн суралцагч, дагалдан суралцагч, ханьсан суралцагч гэсэн гурван төрлийн бүрэлдэхүүнтэй байжээ.

**Түлхүүр үг:** *Их Юань улс, Хубилай хаан, Улсын хөвгүүдийн сургууль, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль, Сартуулын улсын хөвгүүдийн сургууль, Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа, Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа*

## УДИРТГАЛ

Их Юань улс нь Их Монгол улсын залгамж төрийн хувьд Зүүн Азийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг бөгөөд түүний төрийн захиргаа, нийгмийн тогтолцоог бэхжүүлэхэд боловсролын бодлого чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Их Юань улсын ноёрхлын үед Монголын уламжлалт төрийн үзэл санаа болон Хятадын олон зуун жилийн турш төлөвшсөн боловсролын тогтолцоо харилцан уялдаж, төрийн хэрэгцээнд нийцсэн шинэ хэлбэрийн сургалтын байгууллагууд бий болсон байна. Тэдгээрийн дотор төрийн дээд боловсролын байгууллага болох Улсын хөвгүүдийн сургуулиуд нь төрийн түшмэдийг бэлтгэхэд голлох үүрэг гүйцэтгэж байв.

Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулиудын тухай тэмдэглэсэн түүхийн сурвалж бичгүүд цөөхөн ажээ. Энэ тухай тэмдэглэсэн тулгуур сурвалж бичиг бол “Юань улсын судар”<sup>1</sup> юм. Тус сурвалж бичгийн 81-р дэвтэр, “Ойллого 31”, “Сонгож дэвшүүлэх 1”, “Сургууль”-д Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулиудын тухай мэдээ баримтууд тэмдэглэгджээ.

“Юань улсын хууль цаазын бичиг”<sup>2</sup>-г Улсын хөвгүүдийн сургуулиудтай холбоотой зарим мэдээ баримтууд тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал, Их Юань улсын хаадын сургуулийг хөгжүүлэх тухай зарлигууд, сургуулийн сургагч түшмэлтэй холбоотой дүрэм журмуудыг тэмдэглэжээ.

Монгол улсад Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн тухай цөөн тооны зохиол бүтээлүүдэд дурджээ. 2006 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгээс Монголын эзэнт гүрний түүхийг дөрвөн ботиор бичиж хэвлүүлжээ. Ж.Ганболд, Д.Наран, Т.Мөнхцэцэг, А.Пунсаг нарын эрдэмтэд “Монголын Юань улс”<sup>3</sup> номыг хамтран бичжээ. Тус зохиолын дөрөвдүгээр бүлэг болох соёлын хэсэгт Их Юань улсын үеийн боловсролын түүхийг бичсэн байна.

Харин XIII-XIV зууны үеийн Монголын төр ёсны боловсролын түүхийг тусгайлан судалсан хүн бол Д.Наран юм. Тэрээр 2001 онд “Монголын төр ёсны боловсролын түүх (XIII-XIV) зуун”<sup>4</sup> хэмээн зохиолыг бичжээ.

<sup>1</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年。Юань улсын судар. 81-р дэвтэр. Сонгох өргөх ойллого 31. Сонгох өргөх нэгдүгээр. Сургууль. 8-р боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Аким, М.Баярсайхан. УБ., 2016

<sup>2</sup> 《元典章》4册, 中華書局, 2011年。Юань улсын хууль цаазын бичиг (I-X). Хятад хэлнээс орчуулсан Б.Алтанбагана. Монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлэн хятад хэвлэлтэй харгуулж, хэлхээс үйлдсэн С.Амарбаяр, Б.Нацагдорж, Г.Одбаяр, Н.Хатанбаатар. УБ., 2024

<sup>3</sup> Ж.Ганболд, Д.Наран, Т.Мөнхцэцэг, А.Пунсаг. *Монголын Юань улс*. УБ., 2006

<sup>4</sup> Д.Наран. *Монголын төр ёсны боловсролын түүх (XIII-XIV) зуун*. УБ., 2001

Хятад улсад Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн тухай тусгайлан судалж бичсэн хэд хэдэн бүтээлүүд хэвлэгдсэн байна. Тухайлбал, Шэнь Ваньли-гийн “Юань улсын үеийн сурган хүмүүжлийн судалгаа”<sup>5</sup>, Ван Жяньжүнь-ий “Юань улсын үеийн сурган хүмүүжлийг сүвэгчлэн харах нь”<sup>6</sup>, Оу Янжоу-гийн “Хятадын Юань улсын үеийн сурган хүмүүжлийн түүх”<sup>7</sup> зэрэг бүтээлүүдийг дурдаж болно.

Энэхүү өгүүлэлдээ Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулиудын үүсэл, хөгжил, бүтэц, зохион байгуулалт, дүрэм журам, багш ба сурагчдын бүрэлдэхүүнийг цогц байдлаар авч үзэж, санал дүгнэлтээ дэвшүүлэхийг зорилоо.

## НЭГ. УЛСЫН ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛИЙГ БАЙГУУЛСАН НЬ

Их Юань улсын үед Хубилай хааны зарлигаар гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулжээ. Үүнд: 1. Улсын хөвгүүдийн сургууль. 2. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль. 3. Сартуулын улсын хөвгүүдийн сургууль болно. Эдгээр гурван Улсын хөвгүүдийн сургуулийн тухай доор өгүүлбэ.

**1. Улсын хөвгүүдийн сургууль** (国子学-guo zi xue). Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургууль нь Их Монгол улсын Өгэдэй хааны байгуулсан Улсын хөвгүүдийн сургуулиас үүсэлтэй билээ. 1233 онд Их Монгол улсын цэрэг Алтан улсын нийслэл Бяньжин-гийг эзэлж, Богдын алдаршуулах сүм (宣圣庙-xuan sheng miao)-д Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулсан байна. Энэ тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь “Тайзун [Өгэдэй хаан]-гийн зургаадугаар он [1234 он]-ы харагчин могой жил Фэн Жичан-г Улсын хөвгүүдийн сургуулийн ерөнхий багшаар томилж, түшмэдийн хөвгүүд, дүү нараас 18 хүнийг сурагчаар орохыг зарлигдав”<sup>8</sup> гэсэн байдаг. Энэ бол Их Монгол улсын үед байгуулагдсан анхны төрийн сургууль юм.

Хубилай хаан Улсын хөвгүүдийн сургуулийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, тухайн цаг үеийн нэр алдартай эрдэмтэн мэргэдийг сургагч түшмэлээр томилж, сургуулийн дүрмийг шинэчлэн тогтоож, улам боловсронгуй болгожээ. “Юань улсын судар”-ын “Хубилай хааны цаг”-т Улсын хөвгүүдийн сургуулийг шинээр байгуулсан тухай хэдэн хэдэн чухал мэдээ баримтыг тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, “Жунтун-гийн хоёрдугаар он [1261 он]-ы наймдугаар сард Сүхэнь (许衡)-ийг Улсын хөвгүүдийн сургуулийн эрхлэн сургагч түшмэл (国子祭酒)-ээр томилсон”<sup>9</sup> гэжээ. Мөн “Жиюань-ий дөрөвдүгээр он [1266 он]-ы есдүгээр сард Сүхэнь-ийг Улсын хөвгүүдийн сургуулийн эрхлэн сургагч түшмэлээр

<sup>5</sup> 申万里; 《元代教育研究》, 武汉大学出版社, 2007年。

<sup>6</sup> 王建军; 《元代教育管窥》, 中国社会科学出版社, 2012年

<sup>7</sup> 欧阳周; 《中国元代教育史》, 人民出版社, 1994年。

<sup>8</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2029頁。

<sup>9</sup> 《元史》卷4, 本紀第4, 世祖1, 中華書局。北京, 1976年, 73頁。

томилсон”<sup>10</sup> гэжээ. Бас “Жиюань-ий зургаадугаар он [1269 он]-ы долоон сард Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулав”<sup>11</sup> гэжээ. Үүний дараа “Жиюань-ий наймдугаар он [1271 он]-ы гуравдугаар сард Сүхэнь өвчний улмаас Төв бичгийн яамны ажлаас татгалзаж, Мэргэдийг цуглуулах хүрээлэнгийн эрхин сайд, Улсын хөвгүүдийн сургуулийн эрхлэн сургагч түшмэлийн албыг орхив. Хуучин дардасаа буцаан өгч, шинэ дардас гардуулсан. Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулж, дэс сургагч түшмэл, сургагч түшмэл, сургагчийн туслах тус бүр нэгийг томилж, хааны ордны түшмэдийн хажууд ажилладаг монгол, хятад хүүхдүүд болон авьяаслаг сурагчдыг сонгон суралцагч болгосон”<sup>12</sup> гэжээ. Эндээс үзвэл, Хубилай хааны зарлигаар 1269 онд Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулсан бөгөөд анхны эрхлэн сургагч түшмэлээр Сүхэнь-ийг томилсон байна.

1276 онд Их Юань улсын төр засаг Улсын хөвгүүдийн сургуулийн байрыг Их Нийслэлийн чөлгөөгийн сургуулийн захиргааны газар болгосноор хэсэг хугацаанд Улсын хөвгүүдийн сургуулийн сургагч түшмэл, сурагчид тогтсон суралцах байргүй болов. Энэ байдал нь Бухуму зэрэг сурагчдын санааг ихэд зовоох болжээ. Ингээд Бухуму тэргүүтэй сурагчид Хубилай хаанд айлтгал өргөсөн байна. Тэрхүү айлтгалд өгүүлсэн нь “Эрдэмт хүн ардыг соён гэгээрүүлж, зан заншлыг төлөвшүүлэхийг хүсвэл заавал суралцахаас эхэлнэ”, мөн “Хааш чулууг засаж өнгөлөхгүй бол эд хэрэгсэл болдоггүй, хүн суралцахгүй бол ёсыг мэддэггүй” хэмээгээд... Харин өнөөдөр манай сүр жавхлантай их улс Жянь, Линь нутгийг бүхэлд нь эзэмшиж, мөхсөн Сүн улсын өрхийн тоо дор хаяж арван саяд хүрч байна. Энэ бол Таны дээдсийн бурханлаг гавьяа бөгөөд эртнээс нааш урьд байгаагүй, Жинь, Сүй, Тан улсуудын ч зүрхлэн зүйрлэхийн аргагүй юм. Гэвч сургуулийн бодлого одоо хүртэл бүрэн хэрэгжиж амжаагүй байгаад боол нууцхан харамсаж байна. Боол бид урьд нь Таны дээдсийн их нигүүлслийг хүртэж, Күнзийн сургаалын ухаанд суралцаж ирсэн билээ. Таны ариун санааг болгоон эргэцүүлбэл, элдэв угсаатны хүмүүс төрийн албанд олноор зүтгэж байхад монгол хүмүүсийн тоо харьцангуй цөөн тул, боол биднийг ертөнцийн хэрэг явдлыг танин мэдэж, Таны зарлиг, даалгаврыг гүйцэтгэхэд бэлтгэхийг хүссэн бус уу? Гэвч сургалтын тогтолцоо хараахан тогтоогүй, хамтран суралцагчид цөөн байгаа нь, хэдхэн соёлоос сайхан тариа хураахыг, хэдхэн адуунаас хурдан хүлэг олохыг шаардаж буйтай адил бөгөөд боол бид үүнийг амаргүй хэрэг хэмээн эмээж байна. Өнөөгийн байдлаар, хэрэв олон авьяастныг бэлтгэж, Хань ёс хуульд нэвт суралцуулахыг хүсвэл, зайлшгүй эртний ёсоор сургууль боловсролыг хаа сайгүй байгуулсны дараа л боломжтой. Хэрэв “одоо завгүй” хэмээвээс, ядаж Их нийслэлд Улсын хөвгүүдийн сургуулийг өргөн дэлгэр хөгжүүлэх нь зүйтэй. Тухайлбал, арван таван наснаас доош, арван наснаас дээш, авьяас чадвар сайтай монгол хүүхдүүдээс 100 сонгон авч, мөн түшмэдийн хүүхдүүд болон энгийн ардаас шалгарсан авьяастнуудаас 100 сонгон авч, хоол

<sup>10</sup> 《元史》卷4, 本紀第4, 世祖1, 中華書局。北京, 1976年, 116頁。

<sup>11</sup> 《元史》卷4, 本紀第4, 世祖1, 中華書局。北京, 1976年, 122頁。

<sup>12</sup> 《元史》卷4, 本紀第4, 世祖1, 中華書局。北京, 1976年, 134頁。

хүнс, хувцас хэрэглэлд нь тогтсон журам бүхий хангалт олгох хэрэгтэй. Ёс суртахуун, эрдэм чадвар төгөлдөр, багийн жишээ болохуйц хүмүүсийг сонгон авч, дэс сургагч түшмэл, сургагч түшмэл, сургагчийн туслах болгон томилж, тэднээр сурган хүмүүжүүлнэ. Сургалт нь заавал хүний ёс журамд тулгуурлаж, юмс үзэгдлийн зүй тогтлыг ухааруулан, судар номыг тайлбарлан зааж, өөрийгөө засах, гэрийг төвхнүүлэх, улсыг засах, дэлхий дахиныг амаржуулах замыг сургах ёстой. Үүний доор дахин хэд хэдэн салбар ухаан байгуулна. Тухайлбал, бага сургууль, хууль бичиг, тооцооны ухаан зэрэг. Салбар бүрд багш томилж, өөр өөрийн мэргэжлээр сургалт явуулна. Бага сургуулийн салбарт судар ном уншуулж, харилцах, урагш хойш алхах, ахмад дээдсийг хүндэтгэх ёс жаягийг заана. Хуулийн салбарт төрийн албаны хэргийг бүрэн ойлгуулахад анхаарна. Бичгийн салбарт үсэг бичгийн дүрсийг сайтар сургана. Тооцооны салбарт тоо бодлогыг гарштал эзэмшүүлнэ. Зарим нь нэг ухаанд нэвтэрч онцгой авьяастай бол түүгээр нь гүнзгийрүүлэн сургаж, заримыг нь нэг өдрийн дотор ч ээлжлэн дамжуулж сургаж болно. Улсын хөвгүүдийн сургуулийн албан тушаалтнууд эдгээр бүх хэргийг ерөнхийд нь хариуцаж, байнга шалган хянаж, бүхнийг цогцоор нь эзэмшүүлэхийг зорих бөгөөд ёс зүй, утга учрыг нэн тэргүүнд тавина. Илүү чадалтай хүмүүст бичиг зохиол туурвихыг ч зөвшөөрнө. Нар сар, улирлын цагийг даган, сурагч бүрийн авьяас чадвар, сул дорой талыг харгалзан, тухайн хүний хийх ажлыг зааж өгөх ба хичээл хөдөлмөрийг нь үнэлэн шагнах, шийтгэх ёстой. Хичээнгүй сурагчийг дээд байрлалд шилжүүлж, хойрго сурагчийг доод байрлалд буулгана; алдаагаа зассан бол дахин дээд байрлалд шилжүүлнэ. Амралтын өдөр сурагчдыг сум харвахад зөвшөөрнө; амралтын бус өдөр ямар ч шалтгаангүйгээр сургуулиас гаргахгүй. Жилийн хэдэн жилийн дараа, дээд байрлалд сурч буй сурагчдын сурлага амжилттай болбол сургуулийн албан тушаалтан зөвлөн дэмжиж, монгол сурагчийг ямар зэрэглэлд байрлуулах, бусад угсаатныг хэрхэн төрийн албанд оруулахыг тодорхойлно. Амжилт гаргаагүй сурагчийг дахин суралцуулаад, улс төрийн албанд орох боломжтой болохыг хүлээнэ. Дараа нь жил бүр сургуулийн албан тушаалтан тэдний дунд чадварлаг, ухаантайг тодруулж, дүрмийн дагуу төрийн албанд оруулна. Харин эцэстээ зааж сургаж болохгүй сурагчийг гурван жилийн дараа сургуулиас гаргана. Сургуулийн бодлого, суралцагчдын тоо, бүтэц өөрчлөгдөх тохиолдолд цаг тухайд нь мэдээлж байвал сургуулийн үйл ажиллагаанд гэмтэл гарахгүй бөгөөд улс орны авьяастнууд ч харж мэдрэн урган гарна. Үүний дараа муж, хошуу бүрд сургууль байгуулж, ардыг соён гэгээрүүлэхэд ямар ч саадгүй болно”<sup>13</sup> гэжээ. Хубилай хаан Бухуму нарын айлтгалыг сонсоод хүлээн авчээ. Тэгээд Улсын хөвгүүдийн сургуулийг шинэчлэн хөгжүүлэхдээ Бухуму нарын айлтгалд дурдсан зүйлүүдийг хэрэгжүүлсэн нь Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1267 онд Их Юань улсын Хубилай Сэцэн хаан Лю Бинжун-гийн саналыг хүлээн авч, Яньжин хотын ойролцоо шинэ нийслэл байгуулахаар шийдвэрлэв.

<sup>13</sup> 《元史》卷130, 列傳第17, 不忽木, 中華書局, 北京, 1976年, 3164-3166頁。

1272 онд Их Юань улсын төр Яньжин-г албан ёсоор Их нийслэл (Даду) хэмээн тогтоож, хуучин нийслэл Кайпинийг Дээд нийслэл (Шанду) хэмээн өөрчилж, улирлын дагуу нүүдэллэн ордноо сэлгэн суух тогтолцоог хэрэгжүүлжээ. Хубилай хаан Кайпин хотын нийслэлийн байр суурийг хадгалан үлдээж, түүнийг монголчуудын бөө мөргөлийн зан үйл явуулах гол төв, эзэн хааны зуны амралт, ан агнуурын газар болгосон нь Их Юань улсын төрийг уугуул Монгол оронтой холбох чухал гүүр болж байв. Жил бүрийн зун эзэн хаан Дээд нийслэлд хэдэн сар саатах бөгөөд төрийн иргэний ба цэргийн бүх байгууллагууд дагалдан хүн илгээж, ордны хамгаалалтын цэрэг болох хэшигтэн цэрэг ч мөн эзэн хааныг даган умар зүгт нүүдэг байлаа. Ийнхүү хэшигтэн цэрэгт алба хааж байсан Улсын хөвгүүдийн сургуулийн сурагчид хэдэн сарын турш хичээлдээ сууж чадалгүй, жил дараалан ингэж тасалдсанаар сурлагын ажил нь орхигдох аюултай болсон байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанаас дээд нийслэл хотод салбар сургууль нээснээр Шандугийн Улсын хөвгүүдийн сургууль байгуулагджээ.

Дээд нийслэл Шанду-гийн Улсын хөвгүүдийн сургуулийг Их Юань улсын Төмөр хаан 1304 онд байгуулжээ. Энэ тухай “Юань улсын судар”-ын “Төмөр хааны цадиг”-т тэмдэглэсэн нь *“Дадэ наймдугаар он [1304 он]-ы дөрөвдүгээр сард Улсын хөвгүүдийн сургуулийн сурагчдыг Дээд нийслэлд хуваан сургагтун”*<sup>14</sup> гэжээ. Мөн “Юань улсын судар”-ын *“Шане-гийн намтар”-т өгүүлсэн нь “Шане (尚野-shang ye) нь Дадэ зургаадугаар онд Улсын хөвгүүдийн сургуулийн туслах багшаар дэвшин томилогдов. Оюутнуудын дотроос ордны хишэгтэн цэрэгт орсон хүмүүс жил бүр эзэн хааныг даган Дээд нийслэлд морилдог байсан тул ерөнхий сайд Хархасун анх Шане-д Дээд нийслэлд салбар сургууль байгуулж, тэнд сурагчдыг сургахыг тушааж, түүнд зориулан тамга цутгуулан олгожээ. Ийнхүү Дээд нийслэлийн салбар сургалт нь Шане-гээс эхтэй болсон юм”*<sup>15</sup> хэмээн өгүүлжээ. Ийнхүү Дээд нийслэлийн салбар сургууль нь түр зуурын зохион байгуулалт биш, харин албан ёсоор тэнд сургууль байгуулсныг илтгэж байна.

Дээд нийслэлийн Улсын хөвгүүдийн сургууль нь Шанду хотын Күнзийн сүмийн хажууд байрлаж, түүний барилгыг түшиглэн өргөтгөн байгуулжээ. Сү Юүрэнх тэмдэглэхдээ: *“Рэньзун хааны Хуанчин-гийн хоёрдугаар он [1313 он]-д сахин хамгаалах түшмэл Хэшиэн-д хуучин ордныг дахин засварлаж, ордны танхим, хаалга, хашаа хэрмийг сэргээн барьж, баруун талд нь дотуур байр байгуулж, Улсын хөвгүүдийн сургуулийн салбар сургуулийн сурагчдыг хүлээн авахад бэлтгэв”*<sup>16</sup> хэмээжээ.

Их Юань улсын хаан Шанду хот руу нүүдэллэн зусах бүрд Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанаас нэг туслах багш, нэг сургалтын бичиг хариуцсан ажилтан, мөн хэдэн дагалдан сурагчийг хамтаар томилон явуулдаг байв. Ийнхүү Шанду хотын Улсын хөвгүүдийн сургуульд туслах багшаар

<sup>14</sup> 《元史》卷21, 本紀第21, 成宗4, 中華書局. 北京, 1976年, 459頁.

<sup>15</sup> 《元史》卷21, 本紀第21, 成宗4, 中華書局. 北京, 1976年, 459頁.

<sup>16</sup> 许有壬: 《上都孔子庙碑》, 《至正集》卷44.

томилогдож очсон маш олон хүмүүс байдаг бөгөөд тэдний бичсэн шүлэг, тэмдэглэлд тухайн цаг үеийн сургуулийн тухай мэдээ баримтууд тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал, Люгуань гэдэг хүн 1319 онд Шанду хотын Улсын хөвгүүдийн сургуульд туслах багшаар томилогдон өчжээ. Түүний бичсэн шүлэгт өгүүлсэн нь “Газрын хэмжээ нь гурван му, хоосон танхим 10 гаруй”<sup>17</sup> гэжээ. Ийнхүү дээд нийслэл Шанду хотод Улсын хөвгүүдийг сургуулийн салбар сургуулийг байгуулсан нь тухайн цаг үедээ эрчимтэй хөгжсөн байна.

**2. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль** (蒙古国子学-meng gu guo zi xue)”. 1271 онд Хубилай хааны зарлигаар Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль байгуулагджээ. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн нэрийг түүхийн судалгааны зохиол бүтээлүүдэд харилцан адилгүй янз бүрээр орчуулан, тайлбарласан байдаг. Тухайлбал, “Монгол хөвгүүдийн сургууль”, “Монгол улсын хөвгүүдийн сургууль”, “Улсын монгол хөвгүүдийн сургууль” гэх мэтээр орчуулжээ. Гэтэл эдгээр орчуулга нь төдийлөн оновчтой бус санагдаж байна. Тэр ч байтугай зарим түүхийн зохиол бүтээлүүдэд тус сургуулийн оновчтой бус орчуулгыг үндэслэн тус сургуулийг зөвхөн монголчуудыг сургаж байсан хэмээн ташаа тайлбар, дүгнэлт бичсэн байдаг. Ийм учраас тус сургуулийн нэрийн орчуулгын тухай нягтлан үзэж, саналаа хэлье. Хятад хэлээр “Мэн гү гуо зи шүэ (蒙古国子学-meng gu guo zi xue)” буюу үгчлэн орчуулбал “Монгол улсын хөвгүүдийн сургууль” хэмээн орчуулагдана. Энэ нь “Монгол улс” гэсэн улсын нэртэй давхардаж, ойлгомжгүй нэр болно. Уг сургуулийн нэрд орсон “Монгол” гэдэг үг нь улсын нэр биш, харин Хубилай хаан зохиолгосон шинэ бичиг үсгийг зааж байгаа бөгөөд энэ шинэ үсгийг тухайн цаг үед “Монгол үсэг” хэмээн нэрлэдэг байжээ. Тийм учраас Хятад сурвалж бичгүүдэд дөрвөлжин бичгийг “Улсын бичиг”, “Улсын шинэ үсэг”, “Монгол үсэг” хэмээн тэмдэглэдэг юм. Тэгэхээр тус сургууль нь монгол үсгийг зааж сургах зорилготой улсын сургууль байжээ. Ийм учраас тус сургуулийн нэрийг үгчлэн орчуулах биш, утгачлан зөв орчуулах нь зүйтэй санагдана. Тухайлбал, “Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль” хэмээн орчуулбал тухайн сургуулийн нэр нь зорилго, агуулгатайгаа бүрэн тохирч нийцэх ажээ. Тиймээс бид “Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль” хэмээн орчуулах нь зүйтэй.

Хубилай хаан Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийг байгуулсан тухай “Юань улсын судар”-г тэмдэглэсэн нь “Хубилай хаан Жиюань-ий наймдугаар он [1271 он]-ы хаврын цагаан сард сая зарлиг буулгаж нийслэл хотод Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль байгуулж олон хөвгүүдийг сургаж, бараалхлын монгол, Хятад зуун түшмэд жич хишигтэн түшмэдийн хөвгүүд, дүү нараас сонгож сургуульд оруулж сургав. Гэвч тушаалтны тоогүй. “Нэвтэрхий толь бичгийн чухал хураангуй (通鉴辑要-tong jian jie yao)”-г авч монгол үгээр орчуулан бичиж сургана. Суралцагч суралцаж төгсөх үед сэдэв гарган шалгаж асуухад түүний хариулсан нь сайн, нэвтэрхийг нь зүй зохисыг

<sup>17</sup> 柳贯：《五月八日至上都国子监作》，《待制集》卷1。

үзэж түшмэлийн тушаалд томилно”<sup>18</sup> гэжээ. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн үндсэн сурах бичиг нь “Нэвтэрхий толь бичгийн чухал хураангуй” хэмээх номыг шинэ монгол үсгээр орчуулан хэрэглэж байжээ. Уг ном нь Умард Сүн улсын сударч түшмэл Си Магуан-ы туурвисан “Төрд туслах нэвтэрхий толь” зохиолын хураангуй хэмээн үздэг. Энэ номыг Хубилай хааны зарлигаар товчлон хураангуйлан дөрвөлжин бичгээр орчуулан 1282 онд хэвлүүлэн Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн сурах бичиг, гарын авлага болгожээ. Харамсалтай нь энэ ном өнөө үед уламжлагдаж ирсэнгүй билээ.

Хубилай хааны үед байгуулагдсан Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийг Төмөр хаан, Хайсан хаан, Аюурбарвад хаадын үед улам өргөжүүлэн хөгжүүлжээ. Энэ тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь “Төмөр хааны Их эрдэмтийн аравдугаар он [1306 он]-ы хаврын хоёр сард суралцагчид цалин, хүнс нэмж урьдын хуучин хүнтэй бүгд 60 хүн болжээ. Хайсан хааны Жида-гийн хоёрдугаар он [1309 он]-д нөхвөрлөн унших суралцагч 40 хүнийг тогтоосон нь дансанд нэр бүхий суралцагчийн сурлага, асуулгаар илүүг нь нөхнө. Аюурбарвад хааны Яньюү-гийн хоёрдугаар он [1315 он]-ы өвлийн арван сард авсан суралцагч 100 хүнээс монгол 50 хүн, өнгөт нүдтэн 20 хүн, Хятад 40 хүн бөгөөд зуун түшмэдийн хөвгүүд, дүү нарын сургуульд орсон нь 200, 300-аас доошгүй болоход түүний амуу, шүүсийг нэмээд олон иргэний хөвгүүд, дүү нараас 114 хүнийг танхимд данслан эрдэм сургахад суралцагчаар элсүүлэн бүртгэж, үүнээс гадна зохисыг үзэж 50 хүнийг нэмжээ. Анх авсан монгол 20 хүн, Хятад 30 хүний цаас, бийр, бэхийг зөвхөн 30 суралцагчид өгнө”<sup>19</sup> гэсэн байдаг. Эндээс үзэхэд Монгол үсгийн улс хөвгүүдийн сургуульд зөвхөн Монголын язгууртан ноёдын хөвгүүд, дүү нарыг сургадаггүй байжээ. Монголчуудаас гадна өнгөт нүдтэн, хятад түшмэдийн хөвгүүд, дүү нарыг сургаж байв. Тус сургуулийн суралцагчдад цалин олгож байсан төдийгүй хоол хүнсний зардал, бичиг хэрэглэлийг нь улсаас хангадаг байсан нь суралцагчдын суралцах нөхцөл боломжийг нээж, сурах дур сонирхлыг нэмэгдүүлэхэд зохих нөлөөг үзүүлжээ. Үүний үр дүнд тус сургуулийн суралцагчдын тоо нь 200-300 хүн болтлоо нэмэгдсэн байна.

Хубилай хааны байгуулсан Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль нь Пагва ламын зохиосон дөрвөлжин бичгийг сургаж, төрийн түшмэдийг бэлтгэн, төр улсын бодлого, үйл хэрэгт дөрвөлжин бичгийг ашиглахад чиглэгдэж байсан юм. Тус сургууль нь төрийн түшмэдийн хөвгүүд, дүү нарыг сургаж, олон тооны төрийн түшмэдийн бэлтгэн гаргаж, нэлээд амжилтыг олсон байна.

**3. Сартуулын улсын хөвгүүдийн сургууль** (回回国子学-hui hui guo zi xue). Энэ сургуулийн нэрийг янз бүрээр орчуулсан байдаг. Тухайлбал, “Лалын шашинт үндэстний хөвгүүдийн сургууль”, “Сартагтайн улсын хөвгүүдийн сургууль”, “Хотон улсын хөвгүүдийн сургууль” гэх зэргээр орчуулжээ. Бид “Сартуулын улсын хөвгүүдийн сургууль” хэмээн орчуулав.

<sup>18</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2027頁。

<sup>19</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2027-2028頁。

Хубилай хаан 1260 онд Их Монгол улсын хаан ширээнд сууж улмаар 1271 онд “Их Юань хэмээх Их Монгол улс”-ыг байгуулсан билээ. Тухайн үед Хубилай хааны дүү Хүлэгү Дундад Азийн олон улс орныг байлдан дагуулаад “Ил хаант улс”-ыг байгуулсан юм. Түүний байгуулсан улс нь Их Юань улсад харьяалагдан захирагдаж байсан бөгөөд олон талын нягт харилцаатай байв. Тийм учраас Хубилай хаан Ил хаант улсаас олон тооны түшмэдийг татаж, төр улсын албанд хүчин зүтгүүлэх болсноор Их Юань улсын хүн амын доторх өнгөт нүдтэний давхарга бүрэлдэн бий болсон юм. Өнгөт нүдтэнүүд Их Юань улсын төрд үнэнчээр хүчин зүтгэж, төрийн захиргааны байгууллага болон ортог худалдаа, соёлын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Тухайн үеийн Их Юань улсын хүн амыг дөрвөн дэс болгон хуваахад өнгөт нүдтэн нь гуравдугаар дэсэд хамаарч байв. Хубилай хаан өнгөт нүдтэнийг ихэд итгэж, хүндэтгэж байсан учир тэдний соёл боловсрол, шашин шүтлэгийг хөхүүлэн дэмжсэн бодлогыг явуулж байжээ. Үүний нэг тод илрэл бол өнгөт нүдтэний түшмэдийн хөвгүүд, дүү нарыг сургах зорилгоор “Сартуулын улсын хөвгүүдийн сургууль”-ийг тусгайлан байгуулсан явдал юм.

Их Юань улс-Ил хаант улсын харилцаа гүнзгийрэн хөгжиж байсан учраас араб, перс хэлтэй төрийн түшмэдийг сургаж, бэлтгэх явдал чухлаар тавигдах болжээ. Энэ тухай “Юань улсын судар”-т өгүүлсэн нь *“Хубилай хааны Жиюань-ий хорин зургаадугаар он [1289 он]-ы зуны таван сард Дээд бичгийн яамны түшмэд айлтгасан нь “Истифэй (亦思替非-yi si ti fei) бичиг үсэг хэрэглэхэд зохистой тул Бичгийн утгагчийн яамны Ифүдэй халудин (益福的哈鲁丁-yi fu de ha lu ding) тэр үсгийн сурлагад нэвтэрч чадах тул гуйх нь бичгийн дэд сайдын зэрэг өгч аливаа гүн, сайд, дайфү, баян иргэний хөвгүүдийг цөм Хятад хүний сургуульд орох хууль ёсоор сургасугай” хэмээсэнд хаан айлтгасан ёсоор болгожээ*<sup>20</sup> гэв. Энд дурдсан “Истифэй” хэмээн Хятадаар галиглан бичсэн нэр нь Их Юань улсын үеийн араб хэлний нэр юм. Энэ нь араб хэлний “Istifa” гэдэг үгийг галиглал бөгөөд “сонголт” гэсэн утгатай. Энэ үг нь Мухаммедын “Мустафа” (сонгосон нэр) гэх хоч нэрээс үүсэлтэй учир ийнхүү нэрлэх болжээ.

Хубилай хааны зарлигаар 1289 оны найман сард Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийг байгуулсан байна. Хожим Аюурбарвад хааны үед 1314 онд Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулж, түшмэл томилжээ. Есөнтөмөр хааны үед Сартуулын улсын хөвгүүдийн сургуульд олон тооны суралцагчид элсэн орох болов. Энэ тухай “Юань улсын судар”-т бичсэн нь *“Тайдин-гийн хаврын илүү цагаан сард ойрын жилээс гүн сайд дайфү-гийн хөвгүүд, дүү нар жич аливаа иргэний хөвгүүд сургуульд орсон нь олон ажээ. Түүний сургуулийн түшмэл, бас суралцагч 50 гаруй хүн, идээ ундааг нь өгсөн нь 27 хүнээс гадна туслан сургагч түшмэл нэг хүн тавьжээ. Суралцагч 24 хүний амууг цөмийг өгөв”*<sup>21</sup> гэжээ. Ийнхүү Их Юань улсын үед Сартуулын улсын хөвгүүдийн сургууль байгуулагдан хөгжиж, араб, перс хэлтэй төрийн түшмэдийг сургаж, бэлтгэх үүргийг амжилттай гүйцэтгэж байжээ.

<sup>20</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2028頁。

<sup>21</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2028頁。

## ХОЁР. УЛСЫН ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛИУДЫН ЗАХИРГААГ БАЙГУУЛСАН НЬ

Их Юань улсын их нийслэл Хаанбалгас хотод гурван Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа (国子监) байгуулжээ. Тухайлбал, “Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа”, “Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа”, “Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа”-г байгуулсан юм. Эдгээр гурван Улсын хөвгүүдийн захиргаа нь тус бүрдээ нэг харьяалан захирах Улсын хөвгүүдийн сургууль (国子学)-тай байсан нь сургуулийн нэгдсэн захиргаа удирдлагын тогтолцоог бүрдүүлжээ.

Хойд Чи (北齐-bei qi) улсын үед Улсын хөвгүүдийн сургуулийн яам (国子寺)-ыг анх байгуулагдсанаас хойш Сүй, Тан, Сүн улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь хэд хэдэн сургуулийг зэрэг захирч ирсэн уламжлалтай байв. Харин Алтан улсын үед аль хэдийнээ зүрчид үндэстэнд зориулсан “”Зүрчидийн улсын хөвгүүдийн сургууль (女真国子学)”, “Зүрчидийн дээд сургууль (女真太学)”-ийг байгуулж байсан бөгөөд эдгээр нь Улсын хөвгүүдийн сургуультай хамт нэгэн адил Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанд харьяалагдаж байжээ.

Харин Их Юань улсын хувьд арай өөр янзтай байжээ. Нэр томьёоны хувьд Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа, Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь бүгд боловсролын удирдлагын чиг үүрэг хэрэгжүүлж байсан боловч бодит байдал дээр тус бүрдээ зөвхөн нэг л Улсын хөвгүүдийн сургуулийг захирах эрхтэй байв. Энэ нь бодит утгаараа Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь улсын хэмжээний боловсролын удирдлагын байгууллага байх үүргийг сулруулж, харин сургуулийн захиргааны чиг үүргийг илүү тодотгосон явдал байв.

Их Юань улсаас өмнөх үед хүмүүс төвийн албан ёсны сургуулийн талаар ярихдаа ихэвчлэн сургуулийн нэрийг шууд дурддаг байсан бөгөөд Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг онцлон ярих нь ховор байв. Харин Их Юань улсын үед байдал өөрчлөгдөж, “Язгууртны хүүхдүүдийн захиргаа (胄监)”, “Захиргааны сургууль (监学)” зэрэг нэршил түгээмэл хэрэглэгдэх болжээ. Эдгээр нэршлийн утга нь ч тодорхой бөгөөд сургуулийг зааж буй хэрэг юм. Үүнээс үзэхэд Юань улсын үед “жянь (监-jian)” (захиргаа) ба “сюэ (学-xue)” (сургууль) нь бодит байдал дээр нэгэн цогц болж, тэдний шинж чанар нь илүүтэйгээр сургалт, боловсрол олгох байгууллага гэсэн утгыг илэрхийлэх болсон байна.

1277 онд Их Юань улс Монгол үсгийн бичгийн мэргэдийн хүрээлэнгийн доор Монгол үсгийн улсын хөвгүүдийн захиргааг байгуулж, нэг дэс сургагч түшмэл (司业)-ийг томилжээ. 1290 онд Их Юань улсын төрөөс Монгол үсгийн улсын хөвгүүдийн захиргааг илүү боловсронгуй болгож, байгууллагын бүтэц, албан тушаалыг нарийвчлан тогтоосон байна. “Юань улсын судар”-ын “Зуун түшмэлийн ойллого”-д тэмдэглэсэн нь “Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа болон Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн орон

тоо, зохион байгуулалт дараах байдалтай байна. Үүнд: Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь дагалт гуравдугаар дэсэд хамааран. 1277 онд анх байгуулагдаж, дэс сургагч түшмэл нэгийг томилжээ. 1290 онд Хятадын Улсын хөвгүүдийн сургуулийн жишигээр эрхлэн сургагч түшмэл, дэс сургагч түшмэл, захиргааны туслагч түшмэл зэрэг албан тушаалтнуудыг томилжээ. 1317 онд түүний зэрэг дэвийн жинхэнэ гуравдугаар дэс болгожээ. 1320 онд дахин дагалт гуравдугаар дэс болгон бууруулан тогтсон бүтэц бүрэлдэн тогтжээ. Тухайлбал, эрхлэн сургагч түшмэл 1, дэс сургагч түшмэл 2, захиргааны туслагч түшмэл 1, захирлын туслагч 1, бичээч 1, тамга хамаарагч 1 хүнийг томилжээ”<sup>22</sup> гэжээ. Эдгээр нь Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны албан тушаалын бүтэц, зэрэг дэв, удирдлагын зохион байгуулалтыг тодорхой харуулж байна.

1287 оны хоёрдугаар сарын арван тавны өдөр Хубилай хаан Лиүлинь (柳林-liu lin)-д очихдоо Дээд бичгийн яамны зүүн гарын харилцан туслагч сайд Ели (叶李-ye li) дагалджээ. Тэрээр Хубилай хаанд Дээд сургууль (太学-tai xue) байгуулах тухай айлтгахдаа “Түшмэл миний санахад урьдах хаад улс байгуулах эхэнд мэргэдийг цуглуулж, сургахыг нэн тэргүүнд тавьдаг байжээ. Эдүгээ улс байгуулагдсан учир сургууль байгуулахгүй байж хэрхэн болох билээ” хэмээжээ. Хубилай хаан даруйд нь Мэргэдийг цуглуулах хүрээлэнд (集贤院-ji xian yuan)-д дэлгэрэнгүй сургууль байгуулах төлөвлөгөө боловсруулж өгөхийг зарлигджээ. Тухайлбал: Дээд сургууль太学-ийг байгуулах, сурагчид ямар судар ном унших, сургуулийн албан тушаалтан, сурагчдын хоол хүнс, амьдралын журмыг тодорхойлох, дүрэм журам боловсруулах, гаднах Бичгийн сургууль (儒学-gui xue) хариуцах албаны газрыг зохион байгуулах зэрэг бүгдийг бичгээр тайлагнах, хаанд өргөж танилцуулах бэлэн төлөвлөгөө гаргахыг зарлигдав”<sup>23</sup> гэжээ. Ингээд таван өдрийн дараа, хоёрдугаар сарын хорины өдөр Мэргэдийг цуглуулах хүрээлэнгийн урьд ба хожмын бүх Бичгийн сургуулийн мэргэд болон олон албан тушаалтнууд Хубилай хааны зарлигаар цугларч, сургууль боловсролыг хөгжүүлэх асуудлыг хэлэлцжээ. Тэдний хэлэлцсэн асуудлын дотор Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулахтай холбоотой гурван заалт бүхий шийдвэр гарсан байна. Ийнхүү 1287 онд Хубилай хааны зарлигаар Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулжээ.

Их Юань улсын Аюурбарвад хаан 1314 онд Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулжээ. Энэ тухай “Юань улсын судар”-г тэмдэглэсэн нь “Рэньзун хааны Яньюү-гийн анхдугаар оны дөрөвдүгээр сард Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулж, захиргааны албан тушаалтнуудыг томилов. Учир нь тэдний бичиг үсэг нь гаалийн хяналт болон тоо баримтыг шалган нэгтгэхэд шаардлагатай байсан тул хуучин дүрмийн дагуу явуулж, хичээнгүйлэн суралцаж, заалгахыг тушаав”<sup>24</sup> гэжээ. Ийнхүү Хубилай хаан

<sup>22</sup> 《元史》卷87, 志第37, 百官3, 中華書局, 北京1976年, 2191頁。

<sup>23</sup> 《庙学典礼》卷二, 《左丞叶李奏立太学设提举司及路教迁转格例儒户免差》, 浙江古籍出版社1992年, 第29頁。

<sup>24</sup> 《元史》卷81, 志第31, 選舉1, 學校, 中華書局, 北京1976年, 2028頁。

Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийг 1289 онд байгуулснаас хойш 25 жилийн дараа Аюурбарвад хаан түүний хамаарах захиргааг байгуулсан байна.

Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны бүтэц, зохион байгуулалтын тухай мэдээ баримт түүхийн сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэл хомсхон ажээ. “Юань улсын судар”-ын 87-р дэвтэр “Зуун түшмэлийн ойллого-3”-д тэмдэглэсэн нь “*Яньюү-гийн анхдугаар онд Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг байгуулж, иситифэй (亦思替非-yi si ti fei) албан харьяалалгүй хүмүүсийг хамааруулан захируулсугай*”<sup>25</sup> хэмээжээ. Энд дурдсан иситифэй (亦思替非-yi si ti fei) гэдэг нь перс хэлтэй хүмүүсийг хэлж байна. Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь перс хэлтэй сургагч түшмэлээр хичээл заалгаж, перс хэлний орчуулагчдыг бэлтгэн гаргахыг зорьж байжээ.

## ГУРАВ. УЛСЫН ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛИЙН ДҮРЭМ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Сүхэн (许衡) Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг удирдаж байсан үед сурагчдын тоо тун цөөн байсан бөгөөд ихэнх нь монгол язгууртны хүүхдүүд байжээ. Тэрээр голчлон хамт сурдаг сурагчдын туслалцааг ашиглаж, хувийн зааварчилгааны аргыг хэрэгжүүлэн оюутнуудад цэвэрлэгээ, сахилга бат, орж гарах дэг зэрэг зан үйл болон хятад хэл, бичиг үсэг, хятадын соёл, Күнзийн сургаалыг зааж сургасан байна.

Елюй Юүшан (耶律有尚) Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг удирдах болсон үед заах сургалтын ангийг хуваах аргыг хэрэгжүүлж эхэлсэн. Тэрээр “Эрдэмтэн (博士-bo shi)-ийг томилж, сургалтын ажлыг хянах болжээ. Сурагчдыг гурван ангид хуваан сургалт явуулж, эртний сургаалыг тайлбарлаж заах; зөв дуудлага, авиа заах, дээд түвшинд сургаалын арга хэрэглэх, доод түвшинд дадлага сургалтын ажлыг шалгаж байв. Мөн туслах багш нарыг томилж, нэг ангийг хариуцуулах, дүрэм журам тайлбарлах, сургалтын агуулгыг хянах зэргээр сургалтыг зохион байгуулж байжээ.

Аюурбарвад хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийн дүрмийг шинэчлэн, улам боловсронгуй болгож, хэвшүүлэн тогтоожээ. 1315 оны Мэргэдийг цуглуулах хүрээлэнгийн эрхин сайд Жао Мэндяо, Ёслолын явдлын яамны эрхин сайд Юань Миншан нарын төрийн сайд түшмэд Улсын хөвгүүдийн сургуулийн дүрмийг хэлэлцээд хаанд өргөн мэдүүлж, шинэчлэн тогтоосон байна.

Энэхүү шинэ дүрмээр Улсын хөвгүүдийн сургуульд гурван иж бүрэн дүрмийг тогтоожээ. Үүнд: 1. Анги дэвшүүлэх дүрэм (升斋等第制). 2. Шалгалтын онооны дүрэм (考试积分制). 3. Сахилга, шийтгэлийн дүрэм (黜罚科条) болно. Энэ гурван зүйлийн шинэчлэлийн тухай “Юань улсын судар”-ын 81-р дэвтэр “Сонгож дэвшүүлэх-1” тодорхой тэмдэглэсэн байдаг.

“Анги дэвшүүлэх дүрэм”-ийн тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь “*Бичгийн гэрт дэвшүүлэх хэмээнэ. Зургаан бичгийн гэрт нь зүүн ба баруун тийш*

<sup>25</sup> 《元史》卷87, 志第37, 百官3, 中華書局, 北京1976年, 2191頁.

харилцан хандана. Доор хоёр бичгийн гэр нь зүүн этгээдийг Чадал эрдмийг зоогдоно хэмээнэ. Баруун этгээдийг Өршөөлд түшнэ хэмээнэ. Аливаа бичиг унших ба бага сургуулийг тайлбарлан өгүүлэлдэх нийлүүлэх нь хавсарна. Дундах хоёр бичгийн гэр нь зүүн этгээдийг баримтална хэмээнэ. Баруун этгээдийг Зоригийн ёст хэмээнэ. Дөрвөн бичгийг тайлбарлан өгүүлэлдэх ба шүлэг, эгшигийг сурч хичээх нь хавсарна. Дээр хоёр бичгийн гэр нь зүүн этгээдийг Цагийг боловсруулна хэмээнэ. Баруун этгээдийг Өдрийг шинэтгэнэ хэмээнэ. Зурхайт ном, Засагт ном, Шүлэглэлт ном, Шашинт номыг тайлбарлан өгүүлэлдэх ба номын журмыг тодорхойлох зэргийг сурч боловсрох дүрэмт утгыг шалгаж боловсруулах нь хавсарна. Бичгийн гэр бүрийн түшмэлийн тоо адилгүй. Эцсийн сар бүрд түүний боловсруулсан ном бичгийн хичээлийг шалгана. Жич дүрэм хэмжээг зөрчсөнгүй нь дэс дараагаар уламжлан дэвшүүлнэ”<sup>26</sup> гэжээ. Энэхүү анги дэвшүүлэх дүрэм нь Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сургалтын удирдлага, зохион байгуулалтын нэг хэлбэр байв.

Энэ нь Сүн улсын Дээд сургууль (太学)-ийн “Гурван өрөөний арга” (三舍法)-ыг жишиж хөгжүүлсэн арга юм. Тухайлбал, Хойд Сүн улсын үед Ван Аньши (王安石) сургуулийн боловсролыг сайжруулах зорилгоор Дээд сургуульд “Гурван өрөөний арга”-г хэрэгжүүлж, суралцагчдыг гадаад өрөө, дотоод өрөө, дээд өрөө гэсэн гурван ангид хуваасан. Дээрх гурван ангид орох нь тухайн сурагчийн өдрийн шалгалтын болон жилийн эцсийн шалгалтын онооноос хамааран өрсөлдөж ахих замаар явагдсан бөгөөд дээд ангийн сурагчдын сурлагын амжилт сайн байвал шууд албан тушаалд томилогддог байсан. Энэхүү арга нь чадварлаг төрийн түшмэдийг бэлтгэх ба сонгон шалгаруулах үүргийг сургуулийн хүрээнд төвлөрүүлж, өрсөлдөөн, хасалт гэсэн механизмыг сургалтын удирдлагад оруулснаар удирдлагын чадавхыг үр дүнтэй бэхжүүлжээ. Их Юань улсын үед Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа энэ тогтолцоог уламжлан авч хэрэглэхдээ алхам алхмаар хөгжүүлж, улам төгөлдөржүүлсэн юм.

Энэхүү гурван ангийн дүрэм нь хамгийн түрүүнд сургалтын агуулгаас нь дамжин, энгийн түвшнээс дэс дараатай дээд түвшинд ахиж хөгжих байдлаар илэрдэг. Тухайлбал, Ном, бичих сурахдаа эхлээд «Ачлалт ном» (孝经), «Бага суртахуй бичиг» (小学), «Шүүмж өгүүлэл» (论语), «Мэнзи бичиг» (孟子), «Их суртахуй бичиг» (大学), «Хэв дунд» (中庸) зэрэг номыг уншина. Түүний дараа нь «Шүлэглэлт ном» (诗经), «Ёслолт ном» (礼记), «Жоу улсын ёслол» (周礼), «Хавар, намар улс» (春秋), «Зурхайт ном» (易经)-г судална. Доод ангид: голчлон «Ачлалт ном» болон «Бага суртахуй бичиг»-г заадаг. Үүнийг Сүхэн (许衡) ном, бичиг заахад хамгийн чухал, суурь агуулга гэж үздэг байсан бөгөөд үсэг бичиг сурахтай зэрэгцэн зааж болдог байв. Дунд ангид: сургалтын агуулга нь «Шүүмж өгүүлэл», «Мэнзи бичиг», «Их суртахуй бичиг», «Хэв дунд»-ыг хамарна. Энэ нь Жүси (朱熹)-гийн сургах үзэл санааг илэрхийлдэг бөгөөд хүмүүст тэнгэрийн

<sup>26</sup> Юань улсын судар. 81-р дэвтэр. Сонгох өргөх ойллого 31. Сонгох өргөх нэгдүгээр. Сургууль. 8-р боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Аким, М.Баярсайхан. УБ., 2016. т.79; 《元史》卷81, 志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2030頁。

жам ёс (天理)-ыг ойлгуулах үндсэн ном гэж тооцогддог. Дээд ангид: Сурагчид «Шүлэглэлт ном», «Ёслолт ном», «Жоу улсын ёслол», «Хавар, намар улс», «Зурхайт ном» зэрэг ном судар судалж, нэг эсвэл хэд хэдэн номыг сонгож, мэргэжлийн түвшний судалгаанд шилждэг.

Сургалтын зохион байгуулалтын хувьд голчлон заах хичээл (授课) болон даалгавар (作业) гэсэн хоёр үндсэн хэсэгтэй байв. Заах хичээл хоёр үе шаттай явагдана. Эхлээд эрдэмтэн (博士) болон туслах сургагч (助教) нь өгүүлбэр унших, авиан дуудлагыг заана. Дараа нь гол сургагч (正)、сургалтын тэмдэглэгч (录)、ханьсан суралцагч (伴读) дарааллын дагуу давтан заадаг.

Даалгавар нь хоёр төрөл байжээ. Үүнд: Өмнөх өдөр заасан агуулгыг давтах даалгавар хийнэ. Энэ нь оюутны ой санамжийг бэхжүүлэх зорилготой. Шалгалтын зориулалттай бичгийн даалгавар гүйцэтгэнэ. Жишээ нь шатар, шүлэг, номын тайлбар, түүхийн шүүмж зэргийг хийнэ. Ингэснээр суралцсан зүйлсийг илүү гүнзгий ойлгож, хэрэглэж сурах боломжтой. Дараагийн өдөр нь азаар сонгогдсон сурагч даалгавраа давтан хэлнэ. Шатар, шүлэг, номын тайлбар, түүхийн шүүмж зэрэгт эрдэмтэн асуулт гаргаж, сурагч бичгийн бэлтгэлээ бэлдэнэ. Эхлээд туслах багшид үзүүлж, эрдэмтэн баталсны дараа сургалтын тэмдэглэлд (附课簿) тэмдэглэж, үнэлгээний үндэс болгоно. Сурагчийн даалгаврыг туслах багш, эрдэмтэн нар үнэлсний дараа “сургалтын тэмдэглэл” (附课簿) дээр тэмдэглэж, сурагчийн сургалтын түвшинг нэгтгэн үнэлэхэд ашиглана.

Аюурбарвад хааны Яньюү-гийн эхэн онд Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сургалтын удирдагч Чи Лючянь (齐履谦) зургаан ангитай сургалтын зохион байгуулалтыг санал болгосон байна. Энэ нь Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанд зургаан анги байгуулна. Доод хоёр ангид анхан шатны суралцагчдыг оруулна. Тэдэнд “Ачлалт ном”, “Бага суртахуй бичиг” номыг заана. Дунд хоёр ангид «Их суртахуй бичиг» (大学), «Шүүмж өгүүлэл» (论语), «Мэнзи бичиг» (孟子), «Хэв дунд» (中庸)-г зааж, шүлэг судлагчдыг оруулна. Дээд хоёр ангид «Зурхайт ном» (易经), «Шүлэглэлт ном» (诗经), «Хавар, намар ул» (春秋), «Ёслолт ном» (礼记)-г зааж, бичиг судлагчдыг оруулжээ. Улирал бүр суралцсан мэдлэгийг шалгаж, амжилттай суралцсан оюутнууд дарааллын дагуу зэрэглэл ахин суралцана.

Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь анги хуваарилалт болон зэрэг ахихыг нэгтгэж, нэг бүтэн систем болгосноор сургалтын удирдлагын хяналтын чадварыг ихээхэн бэхжүүлсэн юм.

“Шалгалтын онооны дүрэм”-ийн тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь *“Нууцаар шалгана хэмээнэ. Дүрэм хэмжээ Хятад хүнийг өдөр бүр шинэтгэх цаг бүр боловсруулахыг магадална. Монгол, өнгөт нүдтэнийг Зориг ёст эрдмийг баримтлахыг авна. Хоёр бичгийн гэрийн тус сургууль үнэнийг өргөж бичгийн гэрт явж суугаад хоёр жилээс дээш огт зөрчил гаргаагүй нь шалгахад болно. Үнэнийг хугацаалан явж бичгийн гэрт сууж гурван жилээс дээшхийг нь сонгож өргөхөд болгоно. Хятад хүний нууц шалгалт нь тэргүүн сард номын эргэцүүлэл нэгэн зүйлийг шалгана. Дундад сард номын журам нэгэн зүйлийг шалгана. Эцэс*

сард арга асуулт, бодрол хуудас тархаах зарлиг, ухуулах зарлигийн шалгалт нэг зүйлийг шалгана. Монгол, өнгөт нүдтэнийг тэргүүн дунд сард тус бүр номыг тодорхойлох нэгэн зүйлийг шалгана. Эцсийн сард арга асуулт нэг зүйлийг шалгана. Үг ёсон бүрнээ илүүг нь дээд зэргийн болгоод нэг хувь болгоно. Ёсон илүү, үг зүг нь дунд зэрэг болгоод хагас хувь болгоно. Жил бүрийн эцэст тэр жилийн цугларсан хувийг бүхнийг бодож найман хувиас дээш хүрснийг нь дэвшүүлж дээд зэрэг болгоно. Суралцагч 40 хүнийг тоо болгоно. Дотор монгол, өнгөт нүдэн тус бүр 10 хүн, Хятад 20 хүн, жилийн эцэст суралцагчийг шалган сонгоход бүрдэхийг хэрэгсэхгүй. Гагцхүү үнэн эрдмийг авна. Хувь адил, дутуу цөөхнийг нь бичгийн гэрт суусан сар өдрийг өмнө хойно олон цөөнөөр эс хүрсэн зэргийг тогтооно. Жич зэрэгт хүрсэн дутуугүй, нөхсөнгүйг нь түүний жилийн цугларсан хувийг хамтаар хэрэглэхгүй дараа жил дахиж цугларсныг бодно. Сар бүр шинийн хоёрны өдөр эрт бүгдээр мэхийсний хойно тус сургуулийн сургагч түшмэл, туслан сургагч түшмэл бүгдээр сууж нүүрлэн шалгаваас зохих суралцагчдыг удирдаж тус бүр тамгат цаас өгч дүрмийг дагаж сэдэв гарган шалгана. Тус бүр тамгад цаасыг хэрэглэж тус сургуулийн дүрмийг хичээнгүйлэн бичнэ. Нарийвчлан битүүмжлэх ба сийрүүлэн бичихээс бусад нь цугаар сонгож шалгах дүрмийг дагана. Туслан сургагч түшмэл, сургагч түшмэл дэс дараагаар шалгаж тогтооно. Дараа өдөр захирах түшмэл дахин шалгаж нэрийн дэвтрийн дотор дансанд тус бүр олсон хувь тоог бодно. Тус сургуульд хураамжлан хадгалж, жилийн эцэст бүгдээр шалгахыг хүлээнэ”<sup>27</sup> гэжээ. Энэхүү шалгалтын онооны дүрэм нь Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сургалтын зохион байгуулалтын үндсэн арга зам байжээ. Үүнийг тухайн үед “Сургуулийн дотоод шалгалтын дүрэм” (私试规矩) гэж нэрлэгддэг байжээ. Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн шалгалтын онооны дүрэм нь суралцагчдыг төрийн албан сонгогдон томилогдох шалгаруулалтад бэлтгэх зорилготой байв.

Сүхэн-ий удирдлагын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанд суралцагчдын тоо цөөн, ихэнх нь монгол язгууртны хүүхдүүд байсан тул тэд сургалтын дараа шууд төрийн түшмэлээр сонгогдон томилогдож байжээ. Энэ үед тусгай дүрэм журам байсангүй.

Төмөр хааны үед суралцагчдын тоо нэмэгдсэн учир Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сургалтын удирдлагыг дүрэмлэх зорилгоор сурагчийн сонгон томилох дүрмийг баталжээ. Тухайлбал, 1304 оны өвлийн 12-р сард монгол, өнгөт нүдтэн, хятад угсааны суралцагчдаас гурван жилд тус бүр нэг хүнийг сонгож тушаалд томилоно. 1306 оны өвлийн илүү арван сард Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанд монгол, өнгөт нүдтэн, хятад угсааны 200 сурагчийг элсүүлэхээр тогтжээ.

<sup>27</sup> Юань улсын судар. 81-р дэвтэр. Сонгох өргөх ойллого 31. Сонгох өргөх нэгдүгээр. Сургууль. 8-р боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Аким, М.Баярсайхан. УБ., 2016. т.80; 《元史》卷81, 志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2030頁。

Аюурбарвад хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг шинэчлэхээр Лимэн-г томилжээ. 1311 оны өвлийн 12-р сард Лимэн суралцагчдын албан тушаалын томилолтын шалгалтыг дүрмийг тогтоожээ. Тэрхүү дүрэмд зааснаар *“Монгол хүнийг зургаадугаар дэсийн түшмэлээр томилно, өнгөт нүдтэн хүнийг жинхэнэ долоодугаар дэсийн түшмэлээр томилно. Харин хятад хүнийг дагалт долоодугаар дэсийн түшмэлээр томилно. Шалгалтыг монгол хүнээс хөнгөн, өнгөт нүдтэн хүнээс бага зэргийн нарийн, хятад хүнээс бүрэн хэмжээний шалтгалт авна”* хэмээн заажээ. Шалгалтын энэ зарчим нь Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сургалтын болон албан тушаалд томилох системийг холбож, сургалтын удирдлагыг дүрэмлэхэд дэмжлэг үзүүлсэн төдийгүй *“Сайн сурсан нь төрийн албанд орно”* гэсэн сонгон шалгаруулах зарчмыг бүх нийтэд тогтоосон явдал болно.

Төрийн албанд нэр дэвшигчдийг хэрхэн тодруулах тухай Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны дэс сургагч түшмэл Чи Лючянь (齐履谦) шалгалтаар дамжуулан хүн сонгох аргыг санал болгожээ. Тэрээр 1314 онд Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны дэс сургагч түшмэлээр томилогджээ. Тухайн үед төрөөс жил бүр Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаанаас зургаан хүнийг нэр дэвшүүлнэ гэж тогтоосон бөгөөд үүнд: монгол хоёр (6-р дэс), өнгөт нүдтэн хоёр (жинхэнэ 7-р дэс), хятад хоёр (дагалт 7-р дэс) багтана. Нэр дэвшигчдийг сургуульд элссэн дарааллыг харгалзан ангилна. Чи Лючянь хэлэхдээ *“Хэрэв хуучин дүрмийг өөрчлөхгүй бол эрдэмтэн залуус хэрхэн суралцах вэ, улс орон авьяастай хүнийг яаж олж авах вэ?”* хэмээн хэлээд, хуучин тогтолцоог үндэслэн анги дэвших, оноо хуримтлуулах зэрэг дүрмийг тогтоожээ. Тэрээр энэхүү саналаа Жао Мэншүн (赵孟顺), Юань Миншань (元明善) нарын хамтаар хаанд өргөн барьж, Дотоод бичгийн мужийн яамаар хэлэлцүүлж, эцэст нь хааны зөвшөөрлөөр батлагдсанаар Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны шалгалт, онооны систем албан ёсоор батлагдсан байна.

*“Сахилга, шийтгэлийн дүрэм”-ийн тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь “Бууруулах, яллах зурвас бичиг хэмээнэ. Нууц шалгалтаар цугларсан хувьд зохих суралцагч сургаал хичээлийг үл хичээх ба жич аливаа дүрэм хэмжээг зөрчсөнийг эхний удаа нэгэн хувийг торгоно. Дараа удаад хоёр хувийг торгоно. Гурав дахь удаад нэрийг гаргана. Дагаж сургагч, жинхэнэ сургагч түшмэлээс буруушаан гаргана. Жинхэнэ сургагч түшмэл мэдэж бүгд буруушаан гаргахгүй болбоос тус яамнаас хэлэлцэж ял тулгана. Зүй нь сургуульд бүхий суралцагч жилийн эцэст үнэнээр сургуулийн гэрт сууж хагас жил болсон нь хамтаар нэрийг гаргана. Сарын чөлөөг гаргаад гадна бусад чөлөө гүйсныг цугаар бодохгүй. Сургуулийн жинхэнэ сургагч түшмэл жилийн эцэст бүгдийг байцаан үзнэ. Сургуульд байваас зохих суралцагч монгол, өнгөт нүдтэнийг гаргаад өөр хэлэлцэхээс бусад Хятад суралцагч гурван жил нэг номыг нэвтрэхгүй ба жич хичээж сурахгүйг нь сургуулиас гаргана. Түүнээс бусдыг буруушаах, яллах нь*

цугаар хуучин дүрмийг дагана”<sup>28</sup> гэжээ. Энэхүү сахилга, шийтгэлийн дүрмээс үзэхэд гурван зүйлийг маш тодорхой зааж өгсөн байна. Үүнд:

1. Суралцагчдыг дотоод шалгалтаар үнэлж, оноо тооцно. Хичээл сурлагад хайнга хандсан, сургуулийн журам дэгийг зөрчсөн тохиолдолд анх удаа зөрчвөл нэг оноо хасна, дахин зөрчвөл хоёр оноо хасна, гурав дахь удаад нэрсийн жагсаалтаас хасна. Ийм зөрчлийг гол сургагч (学正), сургалтын тэмдэглэгч (录) нар илрүүлэн мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв тэд зөрчлийг мэдсээр байж мэдээлээгүй бол тухайн сургуулийн зүгээс шийтгэнэ.

2. Дээд шатны суралцагчид дэвшсэн боловч сургуулийн журам зөрчвөл анх удаа улсын шалгалтад нэг жилийн хугацаанд оруулахгүй, дахин зөрчвөл нэрсийн жагсаалтаас хасна. Үүнийг мөн сургалтын захирагч, бүртгэгч нар илрүүлэн мэдэгдэх бөгөөд мэдсээр байж мэдээлээгүй тохиолдолд тэднийг ч бас сургуулиас шийтгэнэ.

3. Суралцаж буй сурагчдын хувьд жилийн эцэст бодитоор сургалтад суусан (дотуур байранд сууж суралцсан) хугацаа хагас жилд хүрэхгүй бол нэрсийн жагсаалтаас хасна. Сарын амралтаас бусад бүх төрлийн чөлөөг сургалтын хугацаанд тооцохгүй. Жилийн эцсийн нэгдсэн шалгалт, үнэлгээг сургалтын захирагч, бүртгэгч нар явуулна. Монгол болон өнгөт нүдтэн гаралтай суралцагчдыг тусгайлан хэлэлцэхээс бусад тохиолдолд, хятад суралцагчид гурван жилийн дотор нэг ч судрыг эзэмшиж чадаагүй, эсвэл суралцахад идэвхгүй байвал сургуулиас албадан гаргана. Бусад сахилга, шийтгэлийг хуучин дүрмийн дагуу хэрэгжүүлнэ. Эдгээр гурван заалт нь гурван өөр ангийн суралцагчдад тус тусад нь шаардлага тавьсан байна. Үүний зорилго маш тодорхой бөгөөд суралцагчдын сурлагын түвшин ямар байхаас үл хамааран, хэрэв сургуулийн дотоод журам, сахилга дэгийг зөрчвөл заавал сахилгын шийтгэл хүлээлгэнэ гэсэн утгатай. Үүнд гол хариуцлагыг гол сургагч (学正) болон сургалтын тэмдэглэгч (学录) хүлээнэ.

Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа ч гэсэн нэгэн адил тодорхой сахилга, шийтгэлийн дүрэмтэй байжээ. Их Юань улсын төрөөс дараах байдлаар сургуулийн сахилга, шийтгэлийн дүрмийг тогтоосон байна. Үүнд: “Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны суралцагчид багш, ахмадыг үл хүндэтгэх, ёслолын дэг зөрчих, үг яриа болон үйл хөдлөлөө хянахгүй байх, ном тайлбар, цээжлэлт хангалтгүй байх, даалгавраа биелүүлэхгүй байх, шалтгаангүйгээр хичээл таслах, шалтгаантай ч зөвшөөрөлгүй гарч явах, чөлөө авах хугацааг хэтрүүлэх, үүрэг гүйцэтгэхдээ алдаа гаргах, уур хилэн, баяр хөөрийн улмаас маргалдах, зодолдох зэрэг зөрчил гаргавал гол сургагч (正), сургалтын тэмдэглэгч (录) нар шалган мэдүүлнэ. Багш болон ахмадыг үл хүндэтгэх зөрчлийг тусад нь авч хэлэлцэнэ. Бусад зөрчилд эхний удаад сануулга өгч, давтан болон гурав дахь удаад нь хэр хэмжээтэй нь тохируулан шийтгэнэ. Гал тогооны ажилтан, зарц, хаалгач нар байнга сургуульд ажиллаж, хангалт

<sup>28</sup> Юань улсын судар. 81-р дэвтэр. Сонгох өргөх ойллого 31. Сонгох өргөх нэгдүгээр. Сургууль. 8-р боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Аким, М.Баярсайхан. УБ., 2016. т.81-82; 《元史》卷81,志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2031頁。

үйлчилгээ үзүүлэх ёстой бөгөөд зөрчил гаргавал газар дээр нь шийтгэнэ. Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь боловсролын удирдлагын хамгийн дээд байгууллага тул зургаан танхимын сурагчдыг дарааллаар нь анги дэвшүүлж, хэн нэгэн анги алгасан дэвших ёсгүй. Хэрэв анги дэвших ёсгүй байж дэвшин ахихыг шаардах, эсвэл өмнө нь сургуулийн дүрэм зөрчсөн бол хөнгөн зөрчилд бууруулж, хүнд зөрчилд сургуулиас хасна. Харин багш нарын заах арга зүй буруу байвал хянан шалгагч түшмэд (監察御史) шалгана”<sup>29</sup> хэмээн тодорхой заажээ. Энд онцлон тэмдэглэх нэг зүйл бол Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн захиргааны сахилга, шийтгэлийн дүрэм нь харьцангуй энэрэнгүй, хүнлэг байсанд оршино. Тус дүрмийн шийтгэлийн арга нь үндсэндээ хоёрхон төрөлтэй, тухайлбал сануулга (зөрчил тэмдэглэх) болон сургуулиас хасах явдал байв. Хэдийгээр “бусад шийтгэлийг хуучин дүрмийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн боловч, эх сурвалжийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан уг “хуучин дүрэм” нь одоо тодорхой бус байна. Гэсэн ч дээр дурдсан гурван заалтаас харахад, Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн захиргаа нь алдаа гаргасан суралцагчдад шийтгэл оногдуулахдаа хувь хүний нэр төрийг гутаах шинжтэй арга хэрэглээгүй нь илэрхий байна. Харин иймэрхүү үзэгдэл Сүн улсын үеийн Дээд сургууль (太学)-д гарч байжээ. Сүн улсын Дээд сургуульд алдааны хүнд, хөнгөнөөс хамааран шийтгэлийн нэршлийг “хорих ялтай дүйцэх”, “хүнд гэмт хэрэгтэй дүйцэх”, “цаазын ялтай дүйцэх” хэмээн адилтган хэрэглэж байсан байна.

Аюурбарвад хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийн дүрэмд оруулсан шинэчлэл нь Юань улсын төрийн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог илүү зохион байгуулалттай, шат дараатай, шударга шалгалтад тулгуурласан болгох зорилготой байжээ. Сургалтыг бичгийн гэрээр ангилан, мэдлэг чадварыг тогтмол шалгах, нууц шалгалтаар үнэлэх, сахилга бат зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зэрэг нарийн журам тогтоосон нь боловсролоор дамжуулан төрийн албыг бэхжүүлэх бодлогыг илтгэнэ. Мөн уг дүрэмд үндэстэн ястны онцлогийг харгалзан үзсэн нь Юань улсын олон үндэстний төрийн шинжийг харуулж байна. Иймээс энэхүү шинэчлэл нь тухайн үеийн боловсрол, төрийн захиргааны хөгжилд чухал ач холбогдолтой байв.

Есөнтөмөр хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийг дүрмийг дахин шинэчилсэн байна. Энэ тухай “Юань улсын судар”-г тэмдэглэсэн нь “Тайдингийн гуравдугаар он [1326 он]-ы зуны зургаан сард бас цугларсан хувиар сонгож өргөх болгоод Хубилай хааны хуучин хуулийг дагажээ. Түүний шалгаж авах хууль нь сургуулийг захирах түшмэлээс туурвина. Их төлөв нь урьд хуультай адил бөгөөд сэргийлж хасах нь баахан чанга нарийн болой. Түүний тус сургуулийн жинхэнэ сургагч түшмэл, хоёр хөгжмийг эрхэлсэн түшмэл нэг, данс захирагч түшмэл хоёр, хурайлах түшмэл нэг, жич дэргэдэх ёслолын дагасан түшмэл хуучин хууль нь цугларсан хувьд суралцагчийг өргөж томилно. Хойно цугларсан хувь дээд бичгийн гэрт халагдсаны хойно нас 30 дээших сурлага явдал дүрэм болгохыг нь өргөнө. Хойно сурахыг нь чухам сургагч түшмэл болгоно. Аялгуу

<sup>29</sup> 《元史》卷103, 刑法志2, 中華書局, 1976年, 第2636-2637頁。

эгшгийг нэвтэрч ухаанд сурлага ёс илүү сайхыг нь хөгжмийн эрхэлсэн түшмэл болгоно. Чадал ухаан нэвтэрхий хурцыг нь данс захирах, хурайлах түшмэл болгоно. Цугларсан хувийг халсан тул тэр дэргэдэх ёслолын дагасан түшмэлийг дээд, дунд бичгийн гэрээс өргөнө. Ёслолд боловсронгуй аялгуу гаргах нь саруулыг нь өргөж хавар, намрын тусгахыг захирна. Сар бүрийн шинийн нэгэнд хэлж тайхад олонд тодорхой туслах чадалтайг нь томилно”<sup>30</sup> гэжээ. Ийнхүү Есөнтөмөр хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийн дүрмийг дахин шинэчилсэн нь өмнөх үеийн тогтолцоог залгамжлан, ялангуяа Хубилай хааны хууль журмыг баримтлан илүү нарийн, чанд шалгуур тогтоосон онцлогтой байв. Суралцагчдыг цугларсан хувиар үнэлж, мэдлэг чадвар, авьяас онцлогт нь тохируулан төрийн албанд томилох журам тогтоосон нь боловсон хүчнийг мэргэжлийн түвшинд сонгон шалгаруулах зорилготойг харуулна. Мөн сургалтын явц, сахилга бат, нас, сурлага, чадварыг цогцоор нь харгалзан үзсэн нь боловсролоор дамжуулан төрийн захиргааг бэхжүүлэх бодлогыг улам боловсронгуй болгосныг илтгэнэ. Иймээс Есөнтөмөр хааны үеийн энэхүү шинэчлэл нь Их Юань улсын боловсрол, төрийн албаны тогтолцооны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Их Юань улсын үед төрийн сургуулиудыг тусгай дүрэм журамд тулгуурлан зохион байгуулж, багш, сургагч түшмэл болон суралцагчдыг сонгон шалгаруулах, дэвшүүлэх тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгосон нь төрийн боловсон хүчнийг бэлтгэхэд боловсролыг гол тулгуур болгосныг тодорхой харуулж байна. Хубилай хааны үеэс эхлэн сургагч багшийн албыг албан ёсны дүрэмтэй болгож, шалгалт, хугацаа, шат дараалсан дэвшилд үндэслэсэн мерит зарчмыг тогтоосон нь төрийн сургуулийн суурь тогтолцоог бүрдүүлжээ. Төмөр хаан, Аюурбарвад хаан, Есөнтөмөр хааны үед эдгээр дүрэм журмыг улам нарийсган шинэчилж, шалгалт, хяналтыг чангатган, сургалтын зохион байгуулалт, сахилга бат, үндэстэн ястны онцлогийг харгалзсан зохицуулалтыг тусгасан нь тогтолцооны тасралтгүй хөгжлийг илтгэнэ. Иймээс Их Юань улсын төрийн сургуулийн дүрэм журам нь боловсролоор дамжуулан төрийн захиргааг бэхжүүлэх, чадварлаг боловсон хүчнийг тогтвортой бэлтгэхэд чиглэсэн, төвлөрсөн удирдлагатай, мерит зарчимд суурилсан бодлогын чухал илэрхийлэл байсан юм.

## ДӨРӨВ. УЛСЫН ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛИЙН БАГШ БА СУРАЛЦАГЧИД.

Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулиудын багш нь эрдэмтэн (博士-bo shi), туслах сургагч (助教-zhu jiao), сурган заагч (教授-jiao shou), гол сургагч (學正-xue zheng), сургалтын тэмдэглэгч (學錄-xue lu) гэсэн хэдэн зэрэглэлийн багш нараас бүрдэж байжээ. Энэ тухай “Юань улсын судар”-т тэмдэглэсэн нь “Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуульд эрдэмтэн (博士-bo shi) 2 тушаалтан, туслах сургагч (助教-zhu jiao) 2 тушаалтан, сурган заагч (教授-jiao shou) 2 тушаалтан,

<sup>30</sup> Юань улсын судар. 81-р дэвтэр. Сонгох өргөх ойллого 31. Сонгох өргөх нэгдүгээр. Сургууль. 8-р боть. Эрхлэн хэвлүүлсэн Г.Аким, М.Баярсайхан. УБ., 2016. т.82-83; 《元史》卷81, 志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2031-2032頁。

гол сургагч (學正-xue zheng), сургалтын тэмдэглэгч (學錄-xue lu) тус бүр 2 тушаалтан”<sup>31</sup> ажиллаж байжээ. Мөн “Улсын хөвгүүдийн сургуульд эрдэмтэн (博士-bo shi) 2 тушаалтан, туслах сургагч (助教-zhu jiao) 4 тушаалтныг сонгож томилов. 1304 онд Шанду хотод салбар сургууль байгуулаад туслах сургагч (助教-zhu jiao) 2 тушаалтан, сурган заагч (教授-jiao shou) 2 тушаалтан, гол сургагч (學正-xue zheng), сургалтын тэмдэглэгч (學錄-xue lu) тус бүр 2 тушаалтныг нэмж томилжээ”<sup>32</sup> Үүнээс үзвэл, Их Юань улсын үед төрийн сургуулиудын багшийг сонгон томилж, тэдний зэрэг дэвийг тогтоож өгсөн байна.

Их Юань улс нь олон угсаатныг хамарсан өргөн уудам нутаг дэвсгэрийг захирч байсан тул төрийн удирдлагын тогтолцоонд тохирсон боловсон хүчин бэлтгэх нь нэн чухал асуудал байв. Энэ зорилгыг хангах үндсэн төрийн байгууллагууд нь Улсын хөвгүүдийн сургууль, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль, Сартуулын улсын хөвгүүдийн сургууль байжээ. Эдгээр гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургуулиуд нь тогтсон тооны суралцагчдыг сурган боловсруулж, төрийн албаны түшмэдийг бэлтгэж байв.

Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчдын тоог Хубилай хаан 1271 онд анх 30 хүнээр тогтоожээ. Төмөр хаан 1306 онд суралцагчдын тоог нэмж 60 хүн болгожээ. Хайсан хаан 1309 онд ханьсан суралцагчийн тоог 40 хүн болгов. Аюурбарвад хаан 1315 онд суралцагчдын тоог 100 хүн болгосны дотор монгол 50 хүн, өнгөт нүдтэн 20 хүн, хятад 30 хүн байв. Зуун түшмэлийн хөвгүүд, дүү нараас сургуульд орсон нь 200-300 хүн болжээ. Бусад иргэний хөвгүүн, дүү нараас 114 хүнийг дагалдан суралцагчаар элсүүлжээ.<sup>33</sup> Үүнээс үзвэл, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль 1271 онд 30 суралцагчтайгаар эхэлж, 1315 онд 100 суралцагчтай болж өргөжсөн байна. Суралцагчдын бүрэлдэхүүнд монгол, хятад, өнгөт нүдтэн зэрэг олон үндэстэн багтсан бөгөөд зуун түшмэлийн хөвгүүд, тэдний дүү нар болон бусад иргэдийн хүүхдүүд нэмэгдэж сургуулийн цар хүрээ өргөсөн нь тухайн үеийн нийгмийн бүтцэд нийцсэн өргөн хүрээтэй байсныг харуулж байна.

1269 оны 7-р сард олон чөлгөөгийн Монгол үсгийн сургуулийг байгуулаад суралцагчдын тоог тогтоосон байна. Олон чөлгөө, шилтгээний түшмэдийн хөвгүүд, дүү нараас дээд чөлгөөд 2 хүн, доор чөлгөөд 2 хүн, шилтгээнд 1 хүн элсүүлнэ. Бусад иргэний хөвгүүд, дүү нараас дээд чөлгөөд 30 хүн, доод чөлгөөнд 25 хүнийг элсүүлэхээр тогтжээ. Төмөр хаан 1305 оны өвлийн 10-р сард сургуулийн сурагчдын тоог тогтоохдоо сул шилтгээнд 20 хүн, дээд болон дунд жоу-д 15 хүн, доод жоу-д 10 хүн элсүүлэхээр зарлигджээ.<sup>34</sup> Ийнхүү 1269 онд олон чөлгөөгийн Монгол үсгийн сургуулийг байгуулахад суралцагчдын тоог дээд, доод чөлгөө, шилтгээний түшмэдийн хөвгүүд, дүү нараас нарийвчлан тогтоожээ. Дараа нь 1305 онд Төмөр хаан суралцагчдын тоог дахин тогтоож, сул шилтгээнд, дээд,

<sup>31</sup> 《元史》卷87, 志第37, 百官3, 中華書局, 1976年, 第2191頁。

<sup>32</sup> 《元史》卷87, 志第37, 百官3, 中華書局, 1976年, 第2193頁。

<sup>33</sup> 《元史》卷81, 志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2028頁。

<sup>34</sup> 《元史》卷81, 志第31, 選, 1, 學校, 中華書局, 1976年, 第2028頁。

дунд, доод жоу-д элсүүлэх хүний тоог тодорхойлжээ. Энэ нь сургуулийн бүтэц, элсэлтийг үе шаттайгаар зохицуулж, суралцагчдын бүрэлдэхүүнийг нягтлан төлөвлөж байсныг илтгэнэ.

Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчдын тоог нарийвчлан тогтоосон нь Есөнтөмөр хаан юм. Тэрээр 1325 онд тус сургуулийн багш, суралцагчдын тоог 50 гаруй хүнээр тогтоож, 27 хүнд идээ ундаа өгснөөс гадна туслах сургагч 1 хүн, суралцагч 24 хүнд амуу идэш өгсөн байна.<sup>35</sup> Үүнээс харахад 1325 онд Есөнтөмөр хаан Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн багш, суралцагчдын тоог нарийвчлан тогтоож, 50 гаруй хүнд идээ ундаа олгожээ. Мөн суралцагчид болон туслах сургагчийн хоол хүнсийг хангаж өгсөн нь сургуулийн үйл ажиллагаа нарийн төлөвлөгдсөн, зохион байгуулалт сайтай байсныг харуулж байна.

Улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчдын тоог Хубилай хаан 1270 онд зарлигаар шадар түшмэдийн хөвгүүд, дүү нараас 11 хүнийг сургуульд оруулж, ахмад 4 хүнийг нь Сүхэн-д дагуулж, бага насны 7 хүнийг нь Вансүнь-ийг дагуулжээ. Тус жил Хубилай хааны зарлигаар тус сургуулийн сурагчдын тоог нэмэгдүүлэн 80 хүн болгожээ. Төмөр хаан 1306 онд Улсын хөвгүүдийн сургуулийн сурагчдын тоог монгол, өнгөт нүдтэн, хятад хүн нийт 200 хүн элсүүлжээ. Хайсан хаан 1311 онд сурагчдын тоог 300 хүн болгов.<sup>36</sup> Тус сургуулийн суралцагчдын тоо Хубилай хаан, түүний залгамжлагчдын үед тасралтгүй өссөн нэмэгджээ.

Улсын хөвгүүдийн сургуулиудын сурагчдын бүрэлдэхүүнийг гурван төрөлд ангилна. Үүнд: 1. Сургуулийн суралцагч (学生-xue sheng). 2. Дагалдан суралцагч (陪堂生-peí tang sheng). 3. Ханьсан суралцагч (伴读生-ban du sheng) гэсэн гурван төрөл байна.

1. *Сургуулийн суралцагч* (学生-xue sheng). Улсын хөвгүүдийн сургуулийн үндсэн суралцагчдыг бүрдүүлж, төрөөс албан ёсоор бүртгэн авч, байнгын суурин байдлаар суралцдаг. Эдгээр суралцагчид нь ихэвчлэн хааны угсаа, монгол язгууртан болон төрийн өндөр албан тушаалтнуудын хөвгүүд, дүү нараас бүрдэж байсан нь төрийн эрх мэдэл, боловсрол хоёр нягт уялдаатай байсныг харуулдаг. Тэдэнд төрөөс хүнс, хувцас, сурах бичиг олгож, Күнзийн сургаал, сонгодог бичиг, хууль цааз, захиргааны мэдлэгийг системтэйгээр зааж байжээ.
2. *Дагалдан суралцагч* (陪堂生-peí tang sheng). Улсын хөвгүүдийн сургуульд харьяалалтай боловч сургуулийн үндсэн суралцагчийн адил бүрэн эрх, хангамж эдэлдэггүй байв. Тэд ихэвчлэн орон нутгийн захиргаанд ажиллаж байсан түшмэдийн хөвгүүд, дүү нар байсан бөгөөд тодорхой хугацаанд хичээл сонсож, төрийн албанд ажиллах суурь мэдлэг эзэмшдэг байжээ. Энэ нь Юань улсын төрийн бодлого төв болон орон нутгийн

<sup>35</sup> 《元史》卷81,志第31,選,1,學校,中華書局,1976年,第2028頁。

<sup>36</sup> 《元史》卷81,志第31,選,1,學校,中華書局,1976年,第2029頁。

захиргааг холбох боловсон хүчнийг шаталсан байдлаар бэлтгэхийг зорьж байсныг илтгэнэ.

3. *Ханьсан суралцагч* (伴读生-ban du sheng). Улсын хөвгүүдийн сургуульд албан ёсоор бүртгэлгүй боловч тодорхой хичээлийг сонсох, багш нараас суралцах боломжтой хүмүүс байжээ. Эдгээр нь ихэвчлэн авьяас чадвараараа ялгарсан энгийн гаралтай залуус эсвэл бусад сургуулиас ирсэн суралцагчид байв. Ханьсан суралцагчдын оролцоо нь Их Юань улсын боловсролын тогтолцоо бүрэн хаалттай бус, тодорхой хэмжээнд нийгмийн доод давхаргад нээлттэй байсныг харуулж байна.

Улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчид нь төрийн тусгай хангамжтай байжээ. Хубилай хаан 1287 онд Улсын хөвгүүдийн сургуулиудын суралцагчдад төрөөс олгох хангамжийн хэмжээг тогтоож өгсөн байна. Энэ тухай *“Суралцагчдын хоол: хүн бүр өдөрт нэг жин (500 грамм) гурил, нэг шэн (1 литр) будаа авна. Тос, давс, цуу, амтлагч, хүнсний ногоо, түлшийг зохих ёсоор тооцож өгнө. Ор, ширээ, сав суулга, тогоо, сав, таваг зэргийг тоогоороо шалгана. Гал тогооч хоёр, үйлчлэгч арван хүн байна. Суралцагч бүр цаас, үзэг, будаг хэрэглэнэ. Албанаас эдгээрийг хангана. Сургуулийн ном: олон хэрэглээний бичиг, түүх, философи, зохиол зэрэг номыг албан номын санд хадгална. Сургуулийн хөрөнгө: тусгай арга хэмжээ авснаас хойш, суралцагчдын хоол хүнс болон бүх хэрэгцээг албанаас хангана. Сургуулийн талбайг бэлдсэний дараа орон сууцанд байрлуулна”*<sup>37</sup> хэмээн заажээ. Ийнхүү Хубилай хааны үед Улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчид төрөөс хоол, хэрэгсэл, ном, орон байр зэрэг бүх хэрэгцээг бүрэн хангуулж байсан нь боловсролын тогтвортой, иж бүрэн зохион байгуулалттай байсныг харуулж байна.

Их Юань улсын үеийн Улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчдыг гурван төрөл нь төрийн захиргаанд хэрэгцээтэй боловсон хүчнийг олон түвшинд бэлтгэх зорилготой байжээ. Сургуулийн суралцагчид нь төрийн дээд давхаргын эрх ашгийг хангах бол, хажуугийн суралцагчид орон нутгийн захиргааг бэхжүүлэх үүрэгтэй байв. Харин хамт суралцагчид нь нийгмийн өргөн хүрээний авьяастнуудыг төрийн боловсролын орчинд татан оролцуулах боломжийг бүрдүүлж байжээ. Ийнхүү Улсын хөвгүүдийн сургуулийн суралцагчдын бүтэц нь Их Юань улсын төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

## ДҮГНЭЛТ

Их Юань улсын үед Улсын хөвгүүдийн сургууль, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль, Сартуулын улсын хөвгүүдийн сургууль гэсэн гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургуулийг байгуулжээ. Эдгээр гурван төрлийн Улсын хөвгүүдийн сургууль нь Их Юань улсын үеийн боловсролын гол төв байгууллага юм. Улсын хөвгүүдийн сургууль нь уламжлалт төрийн сургалтын

<sup>37</sup> 王颢点校：《庙学典礼》（外二种），杭州：浙江古籍出版社，1992年，第28-31页。

суурийг бэхжүүлсэн байна. Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль нь дөрвөлжин бичгийг түгээн дэлгэрүүлж төрийн бичиг хэрэгт хэрэглэх төрийн түшмэдийг бэлтгэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Сартуулын улсын хөвгүүдийн сургууль нь араб, перс хэлтэй түшмэдийг сурган төрийн захиргаа, олон улсын харилцаанд чухал хувь нэмэр оруулжээ. Эдгээр сургуулиуд нь Их Юань улсын төрийн бодлого, соёл, боловсролын хөгжилд бодит нөлөө үзүүлж, олон үндэстнийг хамарсан төвлөрсөн төрийн тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Их Юань улсын үед Хаанбалгас хотод Улсын хөвгүүдийн сургууль, Монгол үсгийн улсын хөвгүүдийн сургууль, Сартуулын улсын хөвгүүдийн сургууль тус бүрд нь бие даасан захиргааг байгуулснаар сургалт, удирдлагын зохион байгуулалтыг тодорхой болгожээ. Эдгээр захиргаанууд нь өмнөх үеийнхээс ялгаатайгаар зөвхөн нэг сургуулийг харьяалан захирч, “захиргаа” ба “сургууль” нь бодит байдал дээр нэгэн цогц байгууллага болж хөгжсөн байна. Ялангуяа Монгол үсгийн болон Сартуулын улсын хөвгүүдийн сургуулийн захиргааг үе шаттайгаар байгуулж, бүтэц, албан тушаалыг нарийвчлан тогтоосон нь төрийн хэрэгцээнд нийцсэн төрийн түшмэдийг бэлтгэхэд чиглэсэн бодлогын илрэл байв.

Их Юань улсын үед Улсын хөвгүүдийн сургуулийн дүрэм журам нь үе шаттайгаар боловсронгуй болж, сургалт, шалгалт, сахилга бат, төрийн албанд дэвших тогтолцоог нэгтгэсэн цогц систем болон төлөвшжээ. Анх Сүхэн, Елюй Юүшан нарын үед сургалт зохион байгуулалтын анхан шатны хэлбэр бүрэлдсэн бол Аюурбарвад хааны үед анги дэвшүүлэх, оноо хуримтлуулах, сахилга-шийтгэлийн гурван үндсэн дүрмийг албан ёсоор тогтоосноор сургуулийн удирдлага, хяналт эрс сайжирсан байна. Тухайн үед үндэстэн угсаатны онцлогийг харгалзсан шалгалт, томилгооны зохицуулалт, харьцангуй энэрэнгүй сахилгын бодлого нь Их Юань улсын олон үндэстний төрийн шинж, боловсролоор дамжуулан төрийн захиргааг бэхжүүлэх бодлогын чухал илэрхийлэл болсон байна.

Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулиудын багш нь эрдэмтэн (博士-bo shi), туслах сургагч (助教-zhu jiao), сурган заагч (教授-jiao shou), гол сургагч (學正-xue zheng), сургалтын тэмдэглэгч (學錄-xue lu) гэсэн хэдэн зэрэглэлийн багш нараас бүрдэж байжээ. Их Юань улсын Улсын хөвгүүдийн сургуулиуд нь багшийн тодорхой зэрэг дэв, тогтсон бүтэцтэйгээр ажиллаж, төрийн хяналт дор мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд чиглэж байжээ. Суралцагчдын тоо хаадын үед шат дараатайгаар нэмэгдэж, монгол, өнгөт нүдтэн, хятад зэрэг олон угсаатныг хамарсан өргөн бүрэлдэхүүнтэй болсон нь Их Юань улсын олон угсаатны төрийн онцлогийг илтгэнэ. Суралцагчдыг үндсэн, дагалдан, ханьсан гэсэн гурван ангилалд хуваасан нь төрийн захиргаанд шаардлагатай боловсон хүчнийг олон түвшинд, уян хатан байдлаар бэлтгэх боломжийг бүрдүүлжээ. Төр засгаас хоол хүнс, сурах бичиг, орон байр зэргийг бүрэн хангаж байсан нь Улсын хөвгүүдийн сургуулиудыг тогтвортой, зохион байгуулалттай боловсролын гол төрийн байгууллага болгон төлөвшүүлсэн байна.

### Abstract

During the period of the Great Yuan dynasty, three types of State Schools for the Sons of the State were established: the State School for the Sons of the State, the State School for the Sons of the State in Mongolian Script, and the Sartul State School for the Sons of the State. These three types of schools constituted the principal educational institutions of the Great Yuan dynasty. The State School for the Sons of the State strengthened the foundations of traditional state-sponsored education. The State School for the Sons of the State in Mongolian Script played a particularly important role in disseminating the Phags-pa (square) script and in training officials capable of using it in state administration. The Sartul State School for the Sons of the State trained officials proficient in Arabic and Persian, making significant contributions to state administration and international relations. Collectively, these schools exerted a tangible influence on the political policies, culture, and educational development of the Great Yuan dynasty and were of great importance in strengthening a centralized, multiethnic system of governance.

During the Great Yuan period, independent administrative bodies were established in the capital city of Khanbaliq for each of the three schools—the State School for the Sons of the State, the State School for the Sons of the State in Mongolian Script, and the Sartul State School for the Sons of the State—thereby clarifying the organization of instruction and administration. Unlike earlier periods, each administrative body governed only a single school, and in practice the “administration” and the “school” developed as an integrated institution. In particular, the phased establishment of the administrations for the Mongolian Script and Sartul State Schools, along with the detailed specification of their structures and official posts, reflected a policy aimed at training officials suited to the needs of the state.

During the Great Yuan dynasty, the regulations of the State Schools for the Sons of the State were progressively refined, eventually forming a comprehensive system that integrated instruction, examinations, discipline, and advancement in official careers. In the early stages, under figures such as Sükhen and Yelü Yüshan, the basic framework of instructional organization was established. Later, during the reign of Emperor Ayurbarwada, three fundamental regulations—grade promotion, point accumulation, and disciplinary measures—were formally instituted, resulting in a marked improvement in school administration and oversight. At that time, examination and appointment arrangements that took ethnic characteristics into account, together with relatively lenient disciplinary policies, became an important expression of the Great Yuan dynasty’s multiethnic state character and its policy of strengthening governance through education.

The teaching staff of the State Schools for the Sons of the State in the Great Yuan dynasty consisted of several ranked positions, including scholars (博士, *boshi*), assistant instructors (助教, *zhujiao*), instructors (教授, *jiashou*), chief instructors (學正, *xuezheng*), and academic recorders (學錄, *xuelu*). These schools operated

with clearly defined academic ranks and a fixed organizational structure, focusing on the training of professional personnel under state supervision. The number of students increased gradually during successive reigns, forming a broad composition that included Mongols, Semuren (people of “varied categories”), and Han Chinese, thereby reflecting the multiethnic nature of the Great Yuan state. Students were divided into three categories—regular students, probationary students, and affiliated students—creating flexible, multi-level pathways for training personnel required for state administration. The fact that the state fully provided food, textbooks, and accommodation enabled the State Schools for the Sons of the State to develop into stable, well-organized, and central institutions of state education.